



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 1/37

Биндэр сум

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хаваржилтийг даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, салбар дундын үйл ажиллагааг уяалдуулан зохицуулах зорилгоор Шуурхай штабыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Шуурхай штабын дарга: Г.Өнөболд(Засаг даргын тамгын газрын дарга)

Нарийн бичиг: Г.Нямдолгор (ХААТ-ын мэргэжилтэн)

Гишүүд: А.Гэрэлмаа (ХААТ-ын дарга)

Н.Болор-Эрдэнэ (Байгаль хамгаалагч)

А.Уранчимэг(Татварын Улсын байцаагч)

Ц.Санчирмаа (Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн)

А.Мишээлт(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Х.Гэлэгжамц(МЭТ-ийн дарга)

Ц.Цогтбаатар(МЭТ-ийн мэргэжилтэн)

2.Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Шуурхай штабын дарга (Г.Өнөболд)-д үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2020 оны 02 сарын 16-ны А/14 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН